БАТЛАВ

ЗАСАГ ДАРГА Х.БАТТУЛГА

ДОРНОД АЙМГИЙН БАЯН-УУЛ СУМЫН 4,5,6 ДУГААР БАГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ЦАМХАГТ ГЭРЭЛТҮҮЛЭГ ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР

1. Зураг төсөв хийх үнэдэслэл: Баян-Уул сумын ЗДТГазар, Сумын ОНХСан
2. Захиалагч: Баян-Уул сумын ЗДТГазар
3. Барилга байгууламжийн нэр, байршил: Баян-Уул сумын Бэрх 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт 1, Улз 5 дугаар багийн нутаг дэвсгэрт 2, Өвөр эрээн 6 дугаар багт 1, тус тус шинээр 4 цамхагт гэрэл хийгдэхээр төлөвлөгдсөн.
   1. Архитектор төлөвлөлтийн шаардлага, хүчин чадал: Тус сумын 4,5,6 дугаар багуудын нутаг дэвсгэр алслагдсан захын хороололд гудамжны гэрэлтүүлэг дутмаг учир иргэдийн амьдрах ая тухтай орчинг сайжруулах, орчны шаардлагад нийцсэн 6 талруу тусгалтай хүчин чадал сайтай цамхагт гэрэлтүүлэг хийх шаардлагатай байна. Гэрлийн шон 200мм- ээс багагүй диаметэртэй, 12мм-с багагүй зузаантай, 11 метрээс богиногүй / гэрлийн шон бодит өндөр 9 метрээс багагүй байх/ цамхагт гэрлийн шон нь өндөр хүчдэлийн зориулалттай төмөр бетон тулгуур байж болно. Суурийг М250 марктай бетоноор цутгаж бэхжүүлнэ. Палса төмрөөр стандартын дагуу газардуулгч хийсэн байна.
   2. Цамхагт хийц нь 1.6 метрийн диаметртэй 6 талтай байх бөгөөд хийцийг 32мм-н төмөр труба буюу түүнтэй дүйцэхүйц квадрат төмрөөр гагнаж угсарна. Төмөр хийцэд давхар 6 талтай бэхлэгч тогтоогч хийж өгөх бөгөөд гэрлийн үндсэн суурьтай холбож өгнө. Цамхагийн шонд зориулалтын холбогч хомучгаар бэхлэж өгнө. Цагаан өнгийн төмрийн зориулалттай будгаар будна.
   3. Гэрэл- Гадна талбайн зориулалтын нэг бүр нь 250 ваттаас багагүй 6 ширхэг LED гэрэл байхаар төлөвлөсөн.
   4. Гэрлийн утас- АБВГ 2х6 марктай гадна зориулалтын тэжээлийн утас байх бөгөөд монтажны ил болон далд хэсгийг зориулалтын хуванцар хоолойгоор хамгаална. Салаалагч болон холбогч хэрэгсэлүүд нь стандартын шаардлага хангасан байх
   5. Бусад – Гэрэлтүүлэг нь зориулалтын тэжээлийн хайрцагтай байх бөгөөд автомат таслуур, тоолуур, соронзон болон цагийн зохицуулалт релейтэй байна. Цамхагт гэрлийн үзүүрт нарны эрчим хүчээр тэжээгддэг аюулгүйн гэрлийг / анивчдаг улаан / суулгах шаардлагтай
   6. Гүйцэтгэх хугацаа: 2022 оны 2-р улиралд

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	ГҮЙЦЭТГЭХ ШАЛГУУРУУД
1	Зориулалт хүчин чадал:	- 48 ширхэг 1 толгойтой гэрэлтүүлгийн төмөр шон - 3.80 вт – н 100-с доошгүй метртэй гэрэлтүүлэгийн кабель шугам татах - Үндсэн тэжээлийн кабель татах - Тоолуурын хайрцагыг тус бүрт нь суурилуулах
2	Технологийн шийдэл:	Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжийн барилгын норм дүрэм, гудамж талбайн, замын гэрэлтүүлгийг сонгох ерөнхий зарчим, нормыг баримтлах ба сүүлийн үеийн дэвшилтэт технологийн шийдлүүдийг сонгох
3	Гүйцэтгэх ажлууд:	- Шонгийн суурийн нүх ухах - Шонгийн суурь цутгах - Кабелийн шуудуу ухах - Гадна талбайн 1 толгойтой төмөр шонтой гэрэлтүүлэгч угсрах - Тоолуурийн хайрцаг суурилуулах - 3 фазын хайрцаг суурилуулах - Палса төмрөөр газардуулагч булах Техникийн нөхцөлийн дагуу ажлыг хийж гүйцэтгэнэ.
4	Байгууламжийн үндсэн бүтэц, хийцийн шийдэл:	- Гэрэлтүүлгийн толгой : -Гэрлийн чадал-100вт -Гэрлийн технологи – Лед, линзен – 100 -Гадна гэрэлтүүлэг нь ус чийг болон гадны тоосжилтоос хамгаалсан хамгаалалттай байна. - Гэрэлтүүлгийн шон: -Шонгийн дээд талын диаметр – 60мм -Шонгийн доод талын диаметр – 195мм -Шонгийн толгой - 1 ш -Гэрэлтүүлэгийн шонгийн өндөр газраас дээш 9м- ээс багагүй байна -Шонгийн хэлбэр бөөрөнхий, конусан - Гэрэлтүүлэгийн суурь:

		-Шонгийн суурийн бетонон марк - М250 -Удирдлагын самбар: -3 фазын тоолуур DTS541 тоноглогдсон байх -Хугацааны релейтэй байх -Соронзон пускательтай -Цоожтой байна.
5	Ажлын үе шат , хугацаа	-Ажлын гүйцэтгэх үе шатны ажлын графикийг үйлдэж заавар ирүүлнэ. -Бүх шатны ажлуудад тухай бүр фото зургаар баталгаажуулан ил задгай ажлын акт үйлдэж баталгаажуулах гүйцэтгэлийн зургийг баримтжуулан хавсаргана. -Захиалагч гүйцэтгэгч талуудын байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно. -Ажлын явцад ямар нэг ойлгомжгүй зөрчилдөх зүйл гарвал захиалагч байгууллагад мэдэгдэнэ.

Боловсруулсан:

Засаг даргын орлогч С.Цэрэнбадрал